

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН “ОРОН НУТАГ
ХӨГЖЛИЙН САН”-ИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2018.12.24

Шивээговь сум

АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ:

Нэг. Ажил

- 1.1.Соёлын төвийн дулаан, цэвэр усны шугамыг сольж шинэчлэх
- 1.2.Нийтийн эзэмшлийн төв талбайн засвар, тохижилт
- 1.3.3-р сургуулийн цахилгааны монтажийг хэсэгчлэн шинэчлэх
- 1.4.Сумын төвийн гудамж, талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах
- 1.5.Ахуйн хог хаягдал тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж булах зардал
- 1.6.22 дугаар зөрлөг дээр иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх талбай байгуулах /Сагсны шить/

Хоёр. Бараа

- 2.1.Өвс, тэжээлийн нэгдсэн фондыг нэмэгдүүлэх
- 2.2.Малын үүлдэр угсааг сайжруулах
- 2.3.Нийтийн номын сангийн фонд болон орон нутаг судлах танхимыг тохижуулах
- 2.4.Зүүн гэр хорооллын ундны усны худгийг цахимжуулах, зүүн гэр хорооллын худгийн байрыг засварлах
- 2.5.Эрүүл мэндийн төвд ЭХО томографик 4D аппарат худалдан авах
- 2.6.3-р цэцэрлэгийн гэр цэцэрлэгийг тохижуулах /Гэр, зөөлөн эдлэл/

Гурав. Төсөл, хөтөлбөр

- 3.1.Үндэсний их баяр наадмын зардал
- 3.2.Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээ хийх
- 3.3.Сумын "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих" дэд хөтөлбөрийн арга хэмжээний зардал
- 3.4.Сумын "Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийн арга хэмжээний зардал
- 3.5.Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудад бут, сөөг тарих, усалгаа, арчилгаа, хамгаалалт хийх, цэцэрлэгт хүрээлэнг цэцэгжүүлэх зардал
- 3.6.Бэлчээрийн хортон мэрэгч устгах зардал
- 3.7.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал
- 3.8.Золбин нохой, муур устгах зардал
- 3.9.Зөвлөх үйлчилгээ

АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ:

Нэг. Ажил

1.1. “Соёлын төвийн дулаан, цэвэр усны шугамыг сольж шинэчлэх” ажлын гүйцэтгэгчээр “Чандмань” иргэдийн бүлэгтэй 2018 оны 04 сарын 13-ны өдөр гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2018 оны А/54 дүгээр Захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр хүлээж авсан. Ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Чандмань” иргэдийн бүлэг	100 %	5,000,000	4,985,700	4,985,700	14,300



1.2. “Нийтийн эзэмшлийн төв талбайн засвар, тохижилт”-ын ажлын гүйцэтгэгчээр 1 дүгээр багийн иргэн Г.Золбоотой 2018 оны 05 сарын 28-ны өдөр гэрээ байгуулж ажлыг гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлийг сумын Засаг даргын 2018 оны А/94 дүгээр Захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2018 оны 06 сарын 26-ны өдөр хүлээж авсан. Ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Г.Золбоо	100 %	1,902,900	1,902,000	1,902,000	900



1.3. “3-р сургуулийн цахилгааны монтажыг хэсэгчлэн шинэчлэх” ажлын тендерийг цахимаар зарлаж гүйцэтгэгчээр “Энхжих формат” ХХК-ийг сонгон шалгаруулж 2018.07.04-ны өдөр гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2018 оны А/54 дүгээр Захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр хүлээж авсан. Ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Энхжих формат” ХХК	100 %	20,000,000	19,877,879	19,877,879	122,122



1.4. “Сумын төвийн гудамж, талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах” ажлын гүйцэтгэгчээр “Их эффект” ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Ажлын гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын 2018 оны А/54 дүгээр Захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр хүлээж авсан. Ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Их эффект” ХХК	100 %	5,000,000	4,800,000	4,800,000	200,000

1.5. Ахуйн хог хаягдал тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж булах ажлыг гүйцэтгэгчээр “Илчлэг Шивээ” ОНӨҮГазрыг сонгон шалгаруулж, 2018 оны 01 дүгээр сараас 2018 оны 12 дугаар сарын 31-ыг дуустал гэрээ байгуулан хог тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгүүлсэн. \байрнуудын хогийг 7 хоногт 3 удаа, гэр хорооллын хогийг 7 хоногт 2 удаа зөөвөрлөн хогийн цэгт хүргэсэн.\

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Илчлэг шивээ” ОНӨҮГазар	90%	15,000,000	15,000,000	15,000,000	0



1.6. “22 дугаар зөрлөг дээр иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх талбай байгуулах” /Сагсны шить/-ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/83 захирамжаар байгуулсан. “Энхжих формат” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгчийн буруугаас болон гүйцэтгэгчийн хүсэлтээр гэрээг 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдөр цуцалсан. Гэрээний дагуу олгосон урьдчилгаа санхүүжилт 2.8 сая төгрөг болон гэрээний алданги 700000 төгрөгийн Нэхэмжлэхийг “Энхжих формат” ХХК-д хүргүүлсэн. “Энхжих формат” ХХК-аас 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 2800000 төгрөгийг буцаан байршуулсан. “22 дугаар зөрлөг дээр иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх талбай байгуулах” /Сагсны шить/-ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг дахин хуралдаж, аймгийн хэмжээнд барилгын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг ОСО констракшн, “Илчит сансар” ХХК руу албан тоотоор ажлын саналыг хүргүүлсэн боловч татгалзсан хариуг ирүүлсэн.

Хоёр. Бараа

2.1. “Өвс, тэжээлийн нэгдсэн фондыг нэмэгдүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/22 Захирамжаар байгуулж, иргэн Б.Баяртогтохтой 2 дугаар сард 714 боодол өвсийг худалдан авах гэрээ байгуулсан. Иргэн Б.Баяртогтохын нийлүүлсэн өвсний талаар иргэдээс гомдол ихээр ирсэн тул үлдэгдэл санхүүжилт болох 743801 төгрөгийг олгохгүй байхаар ажлын хэсэг хуралдаж шийдвэрлэсэн.

2018 оны 10 сарын 15-ны өдөр иргэн Т.Батнасангай өвс худалдан авах гэрээ байгуулж, 798 боодол өвс худалдан авсан.

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Иргэн Б.Баяртогтох	100%	10,000,000	5,997,600	4,774,999	6,081
Иргэн Т.Батнасан	100%		5,218,920	5,218,920	




2.2. “Малын үүлдэр угсааг сайжруулах” ажлын хүрээнд сумын Засаг даргын А/69 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг иргэн Г.Даваадоржтой 2018 оны 05 сарын 23-ны өдөр гэрээ байгуулан Керей үүлдрийн хуц-2, эм хонь хургатай 6 /эр хурга/ толгой мал худалдан авсан. 2018 оны 12 сард иргэн О.Эрдэнэтуяатай гэрээ байгуулж, ноолуурын чиглэлээр 4 толгой ухна худалдаж авах гэрээг байгуулсан. Ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Иргэн Г.Даваадорж	100%	2,000,000	1,122,000	1,122,000	-
Иргэн О.Эрдэнэтуяа	100%		878,000	878,000	




2.3. “Нийтийн номын сангийн фонд болон орон нутаг судлах танхимыг тохижуулах” ажлын хүрээнд сумын Засаг даргын А/38 Захирамжаар шууд байгуулагдсан ажлын хэсэг худалдан авалтыг зохион байгуулж 8 төрлийн үзмэр /амьтны чихмэл/ худалдан авсан. Үүнд: Чоно, Үнэг, Дорго, Унага, Зурам, Өмхий хүрэн, ятуу шувуу, Турлиах хэрээ амьтны чихмэлийг тус тус худалдаж авсан. Мөн Орон нутаг судлах танхимд 1ш вакум цонх, сумын Номын санд 5 ширээ 10 сандал худалдан авсан. Ажлыг сумын Соёлын төвийн эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Иргэн А.Сэргэлэн	100%	3,000,000	1,500,000	1,500,000	-
ОСО констракшн	100%		432,500	432,500	
“Оч хийц” ХХК	100%		1,067,000	1,067,000	



2.4. “Зүүн гэр хорооллын ундны усны худгийг цахимжуулах, зүүн гэр хорооллын худгийн байрыг засварлах” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/55 Захирамжаар байгуулж гүйцэтгэгчээр “Сүмбэр зууч” ХХК-ийг шалгаруулж 2018 оны 05 дугаар сарын 08-ны өдөр гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн. Ажлыг сумын “Илчлэг шивээ” ОНӨҮГ-ын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Сүмбэр зууч” ХХК	100%	10,000,000	9,800,000	9,800,000	200,000



2.5. "Эрүүл мэндийн төвд ЭХО томографик 4D аппарат худалдан авах" ажлын тендерийг цахимаар 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн нэг ч тендер шалгараагүй. Захиалагч шууд гэрээг "ИМИ" ХХК-тай байгуулж, 49990150 төгрөгөөр шууд худалдан авалтыг хийсэн. Ажлыг сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"ИМИ" ХХК	100%	50,000,000	49,990,150	49,990,150	9,850



2.6. "3-р цэцэрлэгийн гэр цэцэрлэгийг тохижуулах /Гэр, зөөлөн эдлэл/" худалдан авах барааг нийлүүлэх нийлүүлэгчээр "Мөнх авзага хайрхан" ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулсан боловч гэрээгээ цуцлах албан бичиг ирүүлсний дагуу гэрээг цуцалсан. Шууд худалдан авалтыг "Оч хийц" ХХК-тай гэрээ байгуулж, 5805000 төгрөгөөр худалдан авсан. Ажлыг сумын 3-р цэцэрлэгийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Оч хийц” ХХК	100%	6,027,100	5,805,000	5,805,000	222,100



Гурав. Хөтөлбөр төсөл, арга хэмжээний зардал

3.1. Үндэсний баяр наадмыг 2018 оны 07 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.

Мөрдөх журам	Батлагдсан төсөв	Зарцуулалт
Шууд худалдан авалт	5,000,000	5,000,000

3.2. “Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээ хийх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/34 Захирамжаар байгуулан гүйцэтгэгчээр “Энхжих формат” ХХКийг шалгаруулж 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдөр гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан. Ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
-----------------------------------	-----------------	------------------	---------------	--------------------	----------------

“Энхжих формат” ХХК	100%	5,747,800	5,747,800	5,747,800	-
---------------------	------	-----------	-----------	-----------	---



3.3. Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөр Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг 5 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлуулсан.

	Мөрдөх журам	Батлагдсан төсөв	Зарцуулалт
3.4			
3.5	Шууд худалдан авалт	5,000,000	4,319,350

Хөтөлбөрийн хүрээнд 2 аян, соёл спортын арга хэмжээ 4, эрүүл мэндийг дэмжих ажил 3-ыг зохион байгуулсан.

3.4. Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд аян-1, спортын арга хэмжээ-4, соёл урлагийн арга хэмжээ-2, сургалт сурталчилгаа-5, эрүүл мэндийн үзлэг-2-ыг тус тус зохион байгуулж, 30 гаруй хүүхдэд дэмжлэг үзүүлж ажилласан байна.

	Мөрдөх журам	Батлагдсан төсөв	Зарцуулалт
	Шууд худалдан авалт	5,000,000	5,000,000

3.5. “Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудад бут, сөөг тарих, усалгаа, арчилгаа, хамгаалалт хийх, цэцэрлэгт хүрээлэнг цэцэгжүүлэх” ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/35 Захирамжаар байгуулж гүйцэтгэгчээр “Илчлэг-Шивээ” ОНӨҮГазрыг шалгаруулан гэрээ байгуулж ажлыг гүйцэтгүүлсэн.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Илчлэг-Шивээ” ОНӨҮГазар	100%	2,000,000	2,000,000	2,000,000	-



3.6. Бэлчээрийн хортон мэрэгч устгах зардал

Бэлчээрийн хортон мэрэгч устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын А/48 Захирамжаар байгуулан ажлыг гүйцэтгэсэн. Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрийн 10 байршлын 12 га талбайд устгах ажлыг гүйцэтгэсэн.

Мөрдөх журам	Батлагдсан төсөв	Зарцуулалт
Шууд худалдан авалт	1,000,000	1,000,000



3.7. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зардал

Сумын нутаг дэвсгэрт байрлах "Хаялга" нуурын усанд хүн живж осолдохоос урьдчилан сэргийлсэн Сэрэмжлүүлэг самбарыг нуурын баруун урд болон зүүн хойд талд хийж байрлуулсан. Ажлыг сумын Засаг даргын Тамгын газрын эргэлтийн хөрөнгийн зардалд тусгуулахаар бүртгэлжүүлэх саналыг 2018.11.13-ны өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Мөрдөх журам	Батлагдсан төсөв	Зарцуулалт	Хэмнэлт
Шууд худалдан авалт	500,000	250,000	250,000

3.8. Золбин нохой, муур устгах ажлын гүйцэтгэгчийг сумын Засаг даргын А/26 Захирамжаар байгуулсан ажлын хэсэг иргэн 2-р багийн иргэн Ш.Зоригтбаатараар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж гэрээ байгуулан уг ажлыг зохион байгуулсан. Хаврын нохой устгалаар 23 золбин нохой устгаж ариутгал халдваргүйтгэл хийж төвлөрсөн хогийн цэгт булсан. Мөн 2018 оны 10 сард Улаанбаатар хотын иргэн Г.Чинзоригтой гэрээ байгуулан 54 золбин нохой, муурыг устгасан.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Ш. Зоригтбаатар	100%	1,000,000	500,000	352,000	-
Г.Чинзориг	100%		648,000	648,000	



3.9. Суманд ундны усны цэвэрлэх байгууламж барих ажлын зураг төсвийг хөрөнгө санхүүгийн хүрэлцээгүй байдлаас үүдэн хийгдээгүй болно.

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
-	0%	16,000,000	-	-	-

Тайлагнасан: НБАХМэргэжилтэн З.Баасандалай

Хянасан:

Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цэвээндулам

Засаг даргын Тамгын газрын дарга Д.Отгонжаргал